



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/Н5

Арвайхээр сум

**Комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Өндөр сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажил дууссан тул “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу бага төвөгшилтэй барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0098

Аймгийн Засаг даргын 2023 оны  
.....дүгээр сарын .....-ны өдрийн  
.....дугаар захирамжийн  
хавсралт



**БАГА ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ  
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Б.Оюунсүвд (Барилгын Хөгжлийн төвийн хяналтын инженер)

Д.Бат-Эрдэнэ (Боловсролын ерөнхий газрын мэргэжилтэн)

Б.Баттэмүүжин (Боловсролын ерөнхий газрын Ариун цэврийн байгууламж хариуцсан зөвлөх)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Б.Өсөхбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч)

Б.Даваадагва ("Онги ус суваг" ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер)

Б.Баасандорж (Зураг төслийн "Гурван гал мөнх констракшн" ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллага: Д.Долгор (Баян-Өндөр сумын Цэцэрлэгийн эрхлэгч)

Д.Мөнхбаяр (Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Нарийн бичгийн дарга: С.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)